

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЛЭХЭД АНХААРАХ АСУУДЛУУД

Өнгөрсөн оны эхээр Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдаж, 2002 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн нь Иргэний шүүн таслах ажлын хувьд чухал, шинэ үе шат болсон юм.

Өнгөрсөн богино хугацааг шинэ хуулийг хэрэглэж эхлэх, мөн хуучин хуулиас шинэ хуульд шилжих шилжилтийн үе гэж тодорхойлж болно.

Шинэ хуулиудыг хэрэглэж эхлэх бэлтгэлийг хангах талаар Дээд шүүхийн болон нийт шүүхийн хэмжээнд сургалт зохион байгуулах, хуулийн тайлбар гаргах, зарим журам тогтоох зэрэг тодорхой ажлууд хийгдсэн билээ.

Энэ ажлын хүрээнд "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 2002 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 263 дугаар тогтоол гаргаж нийт шүүхэд хүргүүлсэн бөгөөд уг тогтоолоор шинэ хуулийн гол зүйл, эаалтуудыг шүүхийн ажиллагаанд нэг мөр ойпгож хэрэглэхэд шаардлагатай тайлбарыг өгч чадсан гэж үзэж байна.

Гэвч дээрх хуулийг хэрэглэж эхэлсэн богино хугацаанд хуулийн зарим зүйл заалт нь бусад хуультай болон өөр хоорондоо зөрчилдсөн, хэрэглэхэд ойлгомжгүй, утга санаа давхардсан зэрэг асуудлаар аймаг, нийслэл, сум дундын болон дүүргийн 15 шүүхээс 80 гаруй асуулт, санал ирүүлсэн юм. Иргэний хэргийн танхим ирүүлсэн саналд тулгуурлан уг хуулийн зүйл, заалт бүрийг судалсны үндсэн дээр хуульд нэн даруй оруулах нэмэлт, өөрчлөлт, найруулгын чанартай 27 зүйл саналыг Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, Дотоод хэргийн яаманд хүргүүлсний зэрэгцээ Дээд шүүх тайлбарлах шаардлагатай 33 зүйл, заалт байна гэж үзэж, энэ онд багтаан тайлбар гаргахаар төлөвлөөд байна.

Өнөөгийн байдлаар иргэний шүүн таслах ажилд тулгамдаад байгаа хуулийн зарим зүйл, заалтыг дараах байдлаар ойлгож, нэг мөр зөв хэрэглэж хэвшүүлэх шаардлагатай гэж Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхим үзэж байна.

1. Зарим шүүхэд Иргэний шинэ хуулийг буцааж хэрэглэх заалтгүй байхад хууль хүчин төгөлдөр болохоос өмнө буюу 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө үүссэн харилцаанаас үүссэн маргаантай хэрэгт шинэ хууль хэрэглэж шийдвэрлэсэн буруу практик гарсныг таслан зогсоох хэрэгтэй байна. Иргэний хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний хууль тогтоомжийг буцааж хэрэглэхгүй" гэж заажээ. Үүнээс дүгнэлт хийхэд 2002 онд улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 22.2 хувийг шинээр дагаж мөрдсөн Иргэний хуулиар шийдвэрлэсэн гэсэн шүүхийн тоо бүртгэл эсхүл мэдээ буруу гаргаж ирүүлсэн, эсхүл хуулийн заалтыг шүүх буруу хэрэглэсэн гэж үзэж болохоор байна.

2. Шүүхүүдээс ирж байгаа нэг гол санал бол шүүгчдийн зөвлөпгөөнөөс хэрэг, нэхэмжлэлийг урьдчилан хуваарилах (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (цаашид хуулийн гэх) 5.4), шүүх бүрэлдэхүүнийг томилох (хуулийн 78.1), хэргийн хугацаа сунгах (хуулийн 71.2) заалт амьдралд нийцэхгүй байгаа учир хуулийн заалтыг өөрчлөх тухайд гарч байгаа юм

Энэ хуулийн нэг гол үзэл баримтлал нь шүүгчид гаднаас болон шүүхийн албан тушаалтнаас үзүүлж болох нөлөөллийг хаахад оршиж байгаа юм. Иймээс урьд шүүхийн дарга, Ерөнхий шүүгч шийдвэрлэж байсан хэрэг хуваарилах, шүүх бүрэлдэхүүн томилох, хэргийн хугацаа сунгах асуудлыг шүүгчдийн зөвлөлгөөн хэрэгжүүлэхээр хуульчилсан билээ. Дээрх хуулиар тогтоосон бүрэн эрхийг Ерөнхий шүүгчид буцаан олгох нь шүүхийн шинэчлэлээс буцсан хэрэг болно гэдгийг анхаарах ёстой.

Хэрэг, нэхэмжлэлийг хуваарилахдаа тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс нөхцөл байдлаа харгалзан тойргоор, хэргийн төрлөөр, эсхүл нутаг дэвсгэрийн харъяаллаар хуваарилах зарчмын алиныг сонгохыг өөрсдөө шийдвэрлэх.

Шүүх бүрэлдэхүүнийг жил, хагас жилээр тухайн шатны шүүхийн шүүгчийн зөвлөлгөөнөөс тогтоож хэн нэг нь евчтэй, чөлөөтэй, амралттай тохиолдолд хэн гэдэг шүүгч орлохыг тодорхойлох.

Хэргийн хугацаа сунгахдаа тодорхой хугацаанд (тухайлбал 14, 30 хоногт) шүүгчдээс ямар ямар хэргийн хугацаа сунгах шаардлагатайг нь сонсож, уг асуудлаар шүүгчдийн зөвлөлгөөнийг сард 1-2 удаа хийхээр тооцож зохион байгуулах.

Дээрх асуудлыг хэлэлцсэн Шүүгчийн зөвлөлгөөнөөс тогтоол гаргаж байх нь зүйтэй гэж манай танхим үзэж байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.8-д шүүгчдийн зөвлөлгөөнөөс тухайн асуудлыг хэлэлцээд тогтоол гаргэна гэсэн заалтыг жишиг болгож байгаа юм.

3. Прокурор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо төрийн ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.1-д зааснаар төрийн нэрийн өмнөөс хэргийн оролцогчоор мөн хуулийн 25 дугаар зүйлд заасан эрх, үүрэгтэй оролцоно. Энэ тухай Дээд шүүхийн 2002 оны 263, 2003 оны 2 дугаар тогтоолд тодорхой заасан билээ.

Улсын Их хурал, Засгийн газар, тэдгээрээс эрх олгосон төрийн байгууллагын хүсэлтээр хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, захиран зарцуулах, нөхөн сэргээх төрийн өмчийн зүйлийг ашиглах, захиран эарцуулах, төрөөс төлөх нөхөн төлбөр, олговор зэрэг асуудлаар хуулиар тодорхойлсон эрх үүргээ хэрэгжүүлэх, төрийн байгууллагын албан тушаалтан нэхэмжлэл гаргаагүй, эсхүл татгалзсан буюу эзэнгүйдсэн ээрэг төрийн эрх ашиг зөрчигдсэн тохиолдолд прокурор төлөөлөн оролцох юм.

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан 70/480 дугаар захирамж, тушаал 2002 оны 12 дугаар сарын 5-ны өдөр гарч, уг журмаар цагаатгалын нөхөх олговор авах зорилгоор садан төрлийн холбоо тогтоолгох, цагаатгалын нөхөх олговор авах нэхэмжлэлтэй иргэний хэрэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.1, Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаар прокурорыг төрийг төлөөлж оролцуулах болсон. Энэ журам нь дээр дурьдсан хуулийн заалтад нийцэж байгаа учир хэрэгжүүлэх эрга хэмжээ авах хэрэгтэй.

4. Шүүхийн тогтоол. Шүүгчийн захирамжийг хэрхэн хянах талаар шүүхүүдэд нэгдсэн ойлголт тогтоогүй байна.

Энэ талаар нэлээд олон шүүх, шүүгч асуулт тавьж хуульд өөрчлөлт оруулах санал ирүүлжээ.

Анхан шатны шүүхэд хуулиар олгосон өргөн эрхийн нэг нь өөрийнхөө гаргасан тогтоол, захирамжийг хууль зөрчсөн, илт үндэслэл муутай гэж үзвэл тухайн шатны шүүхийн тогтоол буюу шүүгчийн захирамжаар хүчингүй болгох буюу өөрчилж болох заапт юм Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлд гомдол гаргаж болох болон гомдол гаргахгүй захирамж, шүүхийн тогтоолыг заасан. Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол илт хуульд нийцээгүй, үндэслэл муутай бол хуулийн 124 дүгээр зүйлийн дагуу хүчингүй болгож, өөрчлөх ёстой. Шүүхэд алдаатай гарсан ямар ч шийдвэр байж болохгүй нь ойлгомжтой.

5. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн заалтыг зөв хэрэглэж хэвших хэрэгтэй байна. Хялбаршуулсан журмаар хэрэг шийдвэрлэхдээ талуудын

эрх, үүрэг. юуны өмчө ур дагаврыг нь сайн тайлбарлан өгч, энэ тухай гарын үсэг зурсан баримтыг хэрэгт хавсаргаж байх нь зүйтэй.

Улсын тэмдэгтийн хураамжийг энэ нөхцөлд дараах байдлаар хуваарилж байвал зохино. Тухайлбал, 1.000.000 төгрөг нэхэмжилж, улсын тэмдэгтийн хураамжид 30.000 төгрөг урьдчилан төлжээ.

1. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан тохиолдолд:

Нэхэмжлэгчийн төлсөн 30.000 төгрөгөөс 15.000 төгрөгийг (50 хувь) улсын төсвөөс буцаан гаргуулж нэхэмжлэгчид олгоно.

2. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн бол: Улсын төсвөөс 15.000 төгрөг гаргуулж нэхэмжлэгчид, хариуцагчаас 15.000 төгрөг гаргуулж нэхэмжлэгчид олгоно.

3.Зохигчид эвлэрсэн тохиолдолд:

- Гэрээндээ тэмдэгтийн хураамжийг хэрхэн хуваарилахыг тусгасан бол гэрээнд зааснаар.
- Гэрээнд тусгаагүй бол.

Жишээлбэл: Эвлэрэхдээ 800.000 төгрөг төлөхөөр тохиролцсон бол улсын төсвөөс 30.000 төгрөгийн 50 хувь болох 15.000 төгрөгийг нэхэмжлэгчид, 800000 төгрөгийн улсын тэмдэгтийн хураамж болох 24.000 төгрөгөөс 50 хувь буюу 12.000 төгрөгийг хариуцагчаас гаргуулж нэхэмжлэгчид олгоно.

4. Нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэн бол:

Улсын төсвөөс 15.000 төгрөг, хариуцагчаас 15.000 төгрөг гаргуулж нэхэмжлэгчид олгоно.

Шүүгч дахин оролцож болохгүй тухай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84 дүгээр зүйлийн заалтыг хэрхэн ойлгох вэ?

Хуулийн энэ заалтад зөвхөн иргэний хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг давж заалдах хяналтын журмаар, дахин анхан шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй гэсэн нь Шүүхийн тухай хуулийн 20.6 дахь заалттай зөчилдөг байгаа юм. Бид энэ заалтыг Шүүхийн тухай хуультай нийцүүлэх саналтай байгаа болно. Харин одоогоор анхан шатны шүүхээр уг хэргийг шийдвэрлэсэн шүүгч хэргийг дахин анхан шатаар шийдэхэд орж болохгүй тухай хуулийн заалт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа учир хуулиа биелүүлэх нь зүйтэй.

Харъяаллын хувьд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2-т зааснаар тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгч захирамж гаргаж адил шатны өөр шүүхэд хэргийг шилжүүлэхээр заасан байна. Харъяаллын хувьд шүүхүүд маргахгүй гэсэн хуулийн заалт бий. Хэрэв харъяаллын талаар маргавал тухайн нутаг дэвсгэр дээр харъяа дээд шатны шүүхийн Ерөнхий шүүгч нь Шүүхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6-д зааснаар шийдвэрлэнэ. Харин өөр өөр шүүхүүдийн хооронд харъяаллын талаар маргавал уг хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4-т зааснаар Дээд шүүхийн Танхимын тэргүүн шийдвэрлэх заалттайг анхаарах хэрэгтэй.

Шүүхийн шийдвэрийг шүүх бүрэлдэхүүн олонхийн саналаар гаргадаг зарчимтай. Шүүгчдийн санал зөрж болох авч олонхио дагах нь хамтын шийдвэр гаргах гол нөхцөл болдог. Энэ үүднээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.4 дэх заалт дээрх зарчимд харшилж байгаа юм. Харин ийм санал зөрөлдөөн зөвлөлдөх тасалгаанд гарвал шүүгчдийн гаргасан саналыг зөвлөлдөх тасалгааны нууцыг хадгалах үүднээс дугтуйнд хийж, лацдаж хэрэгт хавсаргаж байна. Энэ санал нь хэрэг маргааныг дээд шатны шүүх хянах үндэслэл болохгүй бөгөөд зөвхөн хэргийн оролцогчид гомдол гаргавал гомдлын дагуу хамтад нь хэргийг хянах үндэслэл болно.

Шинээр илэрсэн нөхцөл байдлаар хэргийг зөвхөн тухайн шатны шүүх хянана. Хуульд тусгай заалт байхгүй боловч хэрэв шинэ нөхцөл байдал илэрсэн гэж шүүх үзвэл шинэ нөхцөл байдлыг шийдвэртээ тогтоож, өмнө нь гарсан шийдвэр, магадлал, тогтоолоо хүчингүй болгоно гэж Иргэний хэргийн танхим тогтсон болно.

Давж заалдах бопон хяналтын шатанд хэрэг маргааныг нарийн нягт хянах шаардлага гарч байна

Давах шатанд 14 хоногт, хяналтад 30 хоногт, хяналтын шатны тогтоолыг эс зөвшөөрвөл Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид 30 хоногт шийдвэр, магадлал, тогтоолыг гардаж авснаас хойш хэргийн оролцогчид гомдол гаргах ёстой.

Дээд шүүхийн ачаалал эрс өссөн. Зөвхөн өнгөрсөн оны сүүлийн хоёр сард 112 хэрэг шүүх хуралдаанаар хэлэлцсэний 70 гаруй хувьд зохигч, гуравдагч этгээд, өмгөөлөгч оролцсон байна.

Сүүлийн үед Дээд шүүхийн хяналтын шатанд хэргийг шууд хянуулах хандлага илт өсч ачааллыг эрс нэмж байна.

Иймд зөвхөн хууль буруу хэрэглэсэн асуудлаар Дээд шүүх хэрэг хянахыг анхаарч, зөвхөн ийм гомдолтой хэргийг хуулийн шаардлага хангуулж ирүүлж байвал зохино.

2003 онд Иргэний шүүн таслах ажилд тавих гол зорилтыг шинэ гарсан хуулиудыг сайтар судалж, шүүн таслах ажилд нэг мөр ойлгож, зөв хэрэглэх, оролцогчийн эрхийг хангах, шүүхийн шийдвэрийг хууль ёсны ба үндэслэлтэй байх зарчмыг хангаж, шүүхийн алдааг эрс бууруулахаар тодорхойлж байгааг анхаарч ажиллах хэрэгтэй байна.

ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Р.ЖАМЪЯНЧОЙЖИЛ